



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 8/144

Улаанбаатар хот

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн
эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын
салбар комиссыг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийн 2 дугаар хэсгийн 2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсугай.

Салбар комиссын
дарга:

Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Боловсролын хэлтсийн Сургалтын арга
зүй, багшийн мэргэжлийн хөгжил,
гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан
ахлах мэргэжилтэн
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын
хэлтсийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил
хамгааллын мэргэжилтэн
Эрүүл мэндийн төвийн ерөнхий их эмч
Эрүүл мэндийн төвийн яаралтай тусламжийн
эмч
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн
зөвлөлийн төлөөлөл
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
хэлтсийн Ахмад настан, хөгжлийн
бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Нарийн бичиг:

2.Салбар комиссын үйл ажиллагааг холбогдох журмын дагуу удирдан зохион байгуулж, арга зүйгээр хангаж ажиллахыг Салбар комисс (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/67 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

AJIL\2025 он ажил\захирамж

1225010439